

Ц.БАТТУЛГА, Ц.ТӨРБАТ, Н.БАЯРХҮҮ, Т.ИДЭРХАНГАЙ\*

### ТЭХТИЙН ГОЛЫН РУНИ БИЧЭЭС

Баян-Өлгий аймгийн нутаг эртний түүх соёлын дурсгалаар нэн баялаг бөгөөд XIX зууны сүүл үеэс эхлэлтэй судалгаа, шинжилгээний үр дүнд одоогийн байдлаар бууц суурин, булш хиргисүүр, хадны зураг, буган чулуу, хүн чулуун хөшөө, төвд, тод болон руни бичгийн дурсгалууд зэрэг эртний судлалын бүхий л төрлийн дурсгалууд илэрч олдсоор байгаа билээ.

Үүний дотор эртний Түрэгийн руни бичгийн дурсгал 10-аад тоотой олноор байгаа бөгөөд тус бүс нутгаас цаашдаа ч илэрч олоход нь дамжиггүй юм.

Тэдгээр дурсгалуудыг жагсаавал:

1. Бага Ойгорын бичээс [3]
2. Дэлүүн сумын төвийн бичээс [11; 29]
3. Зүүн оройн өвөлжөөний бичээс [23]
4. Зүрх уулын бичээс [4; 11; 12; 25; 26]
5. Олон нуурын бичээс [25; 26; 5; 29; 6]
6. Хар Магнайн бичээс [18; 7; 29]
7. Эрээн Харганатын бичээс [25; 26; 8; 9]
8. Өртөөн булагийн бичээс [1]

Эдгээр бичээсийн судалгааны тойм “Монголын руни бичгийн бага дурсгалууд (Тэргүүн дэвтэр) [10]” хэмээх бүтээлд хэвлэгдсэнээс гадна Б.Напил казах хэлнээ орчуулж зарим бичээсийг уншлага судалгааг дахин нягталсан байна [2].

9. Цагаан голын эхийн түрэг бичээс.

Энэ бичээсийг Цагаан голын хөндийд ажилласан Монгол-Америк-Оросын хамтарсан хадны зураг судлалын хээрийн шинжилгээний анги анх олж илрүүлжээ [28]. Уг бичээсийг одоогоор хараахан тайлж уншаагүй байна.

Мөн эдгээрээс гадна саяхан нэгэн бичээс шинээр олдсоныг толилуулья.

Бид Монгол Алтай Судлалын Хүрээлэнгийн “Монгол Алтайн баруун хэсгийн түүх, археологийн дурсгалууд” төслийн хүрээнд 2005 [19; 20] болон 2006 онд Баян-Өлгий аймгийн нутгаар археологийн хайгуул судалгаа хийсэн билээ. Тус төслийн зорилго нь Баян-Өлгий аймгийн түүх археологийн дурсгалуудын хайгуулыг 1:100,000 масштабтай хийж, улмаар ГМС-д тулгуурласан мэдээллийн сан үүсгэхэд оршиж байгаа билээ. Хайгуулын үр дүнд тус аймгийн нутагт одоогийн байдлаар түрэг, уйгурын үеийн 200 орчим хүн чулуун хөшөө, хүрэл, төмрийн түрүү үеийн буган чулуун хөшөө хэдэн арав, түүхийн олон үед холбогдох булш оршуулга, хиргисүүр хэдэн мянга илэрч олноор байна.

\* Ц.Баттулга, МУИС-ийн Түрэг судлалын төвийн эрхлэгч, доктор, дэд профессор  
Ц.Төрбат, МУБИС-ийн ТНУС-ийн Монголын Түүхийн гэхийн багш, доктор, дэд профессор  
Н.Баярхүү, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан  
Т.Идэрхангай, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Ирвэс ( [X]ᠯᠷᠦᠨᠲᠦ ( irbič [ä] ) хэмээх үг нь эртний түрэг хэлний толь бичигт irbič, irbiz хэмээн тэмдэглэгдсэн байдаг [15] ч монгол, түрэг хэл аялгуунуудад irbis, irbiš, ilbis, jilbis [24] гэх мэт олон хувилбараар тохиолдож байна.

## SUMMARY

### Tekht runic inscription

Tekht runic inscription is located 50 km from the southwest of Altantsufts Sum, which is in the boundaries of Bayan-Ulgii aimag (GPS: 48°41.07.9", 090°26.24.1", 2537m).

The inscription was masterly engraved as single line in runic. Since the letters were engraved using a sword, dagger, knife or a similar tool, their depths are not so deep.

Origin of the inscription;

ᠶᠣᠰᠢᠯᠠᠷᠠᠨᠲᠦ

Transliteration;

i r b č ä r p s ᠨᠴ ᠨᠲ

Transcription;


irbičä erip sančinti

Translation;


Snow leopard was chased and speared.

## НОМЗҮЙ

1. Н.Базылхан, Көне түрик бігіктастары мен ескерткіштері (Орхон, Енисей, Талас), -Қазақстан тарихы туралы түркі деректемелер, Алматы, 2005.
2. Базылханұлы Н, Моңғолиядан жаңадан табылған түрік бітік жазулары, -Хабарлары, Қазақ Республикасының білім және ғылым министрлігі мен ұлттық ғылым академиясының (Известия, Министерства образования и науки республики Казахстан, Национальнй Академии Наук РК), 5 (229), 2000, 68-75.
3. Ц.Баттулга, Бага Ойгорын эртний түрэг бичээс, - Алтай аргамжаа (Altan Argamj), Vol. 2, 2/1998, МУИС, Олон улсын дээд сургууль, Улаанбаатар, 1998, 80-83.
4. Ц.Баттулга, Зүрх уулын бичээс, -МУИС Монгол судлалын дээд сургууль, Эрдэм шинжилгээний бичиг, боть VII, дэвтэр 6, Улаанбаатар, 1998, 88-90.
5. Ц.Баттулга, Олон нуурын түрэг бичээс, - МУИС Монгол судлалын дээд сургууль, Эрдэм шинжилгээний бичиг, Боть XIII (139), дэвтэр 3, Улаанбаатар, 1995, 101-103.
6. Ц.Баттулга, Алтай нутаг дахи руни бичгийн судалгааны товч тойм, -Acta Mongolica, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Tom.2 (208), 85-90.
7. Ц.Баттулга, Хар Магнайн эртний түрэг бичээс, -Археологийн судлал, Tom.XIX, fasc.11, Улаанбаатар, 1999, 91-93.
8. Ц.Баттулга, Эрэн Харганатын түрэг бичээс, - Археологийн судлал, Tom.XV, fasc.10, Улаанбаатар, 1995, 65-67.
9. Ц.Баттулга, Эрэн Харганатын түрэг бичээсийг дахин нягтлах нь, -Mongolian Studies, №10, Seul 2000, pp.147-153.
10. Ц.Баттулга, "Монголын руни бичгийн бага дурсгалууд (тэргүүн дэвтэр), -Corpus Scriptorum, Tom. I, Улаанбаатар, 2005, 57-60.



Бичээс буй хадны ерөнхий байдал.



Тэхтийн голын түрэг бичээс